



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/323

Улаанбаатар хот

“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын хүнсний хог хаягдал дахин боловсруулах төслийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 184,140,000.0 (нэг зуун наян дөрвөн сая нэг зуун дөчин мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2024 оны 10 дугаар сарын 10 -ны өдрийн
 А/33 дугаар тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хот тохижилтын газар ОНӨААТҮГ

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Ашиглалтад авсан он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэлд авах | | Эх үүсвэр |
|-----------------------------------|--------------------------|--------------|---------------------|--------------|-------------|------------|---------------|----------------------|-----------------|
| | | | | | | | Нэгжийн үнэ | Нийт үнэ | |
| 1 | Навч хаягдал сорох машин | MAMUT PRO BT | 2024 | Шинэ | Ш | 4 | 46,035,000.0 | 184,140,000.0 | Төслийн хөрөнгө |
| Нийт бүртгэх хөрөнгийн дүн | | | | | | | | 184,140,000.0 | |